



Аудитын код: САГ-2018/111/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: Tserendorjd@audit.gov.mn

Голден пэйж аудит ХХК

Захирал С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Аудитор Б.Одгэрэл
Утас: 70117179 Цахим хаяг: odgerel@goldenpageaudit.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1. Аудитын гэрчилгээ.....	1
2. Аудитын тайлан.....	1
2.1 Оршил.....	1
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	3
2.5 Дотоод хяналт	3
2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7 Шилэн дансны мэдээлэл.....	3
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар.....	4
2.9.2 Өглөг, авлагын талаар	5
2.9.3 Худалдан авах ажиллагааны талаар.....	5
2.9.4 Мөнгөн хөрөнгийн талаар.....	6
2.9.5 Зардлын талаар	6
2.9.6 Дотоод хяналтын талаар.....	6
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	7
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	7
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	8
3.1 Үндсэн хөрөнгийн талаар.....	9
3.2 Үндсэн хөрөнгийн талаар.....	10
3.3 Өглөг, авлагын талаар.....	11
3.4 Худалдан авах ажиллагааны талаар.....	12
3.5 Мөнгөн хөрөнгийн талаар.....	13
3.6 Дотоод хяналтын талаар.....	14
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	20



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Я.ТӨМӨРБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол, Монгол Улсын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын Улсын Их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр 30,752.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 19,080.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан;
- Актлагдсан болон данснаас хассан хөрөнгөнд хамаарах 4,770.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны дүнг хорогдуулаагүй;
- Гадаад оюутны сургалтын төлбөр, буфет, заалны түрээсийн төлбөр, хандивын орлого болон тендерийн материалын 2,457.1 сая төгрөгийн орлогыг бэлнээр хүлээн авч зарцуулсан ба кассын бүртгэлийн дэвтэр хөтлөөгүй;
- Тайлант оны эцэст 578.3 сая төгрөгийн авлага, 305.2 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Худалдан авах ажиллагааны тендер зарласан боловч тендер сонгон шалгаруулалтын хуулийг мөрдлөг болгон ажиллаагүй;
- Дотоод хяналтын 2 ажилтантай ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байдал, үнэлгээ, хэмжилт, толилуулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1 Оршил

Монгол Улсын Их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Төмөрбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах, өглөг, авлагын дүнг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, актлагдсан болон данснаас хассан үндсэн хөрөнгөнд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг хорогдуулах, төрийн өмчийн түрээсийн гэрээг байгуулан ажиллах, нэмэгдсэн болон данснаас хасагдсан үндсэн хөрөнгөнд зохих зөвшөөрөл, шийдвэр авах зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Улсын Их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 6-наас 2018 оны 3 дугаар сарын 14-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Голден пэйж аудит” ХХК-ийн аудитын баг гүйцэтгэв.

Аудитаар Монгол Улсын Их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Их сургуулийн Санхүү, эдийн засгийн газрын даргын 2018 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 603 тоот албан бичгээр “Голден пэйж аудит ХХК”-д ирүүлсэн.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их сургууль нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Дээд боловсролын тухай, Боловсролын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д “Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино”, 4 дүгээр зүйлийн 4.2-т “Их сургууль нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага байх бөгөөд их сургууль нь магистр, докторын сургалт дагнан эрхэлж болно” хэмээн тус байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлсон байна.

Монгол Улсын Их сургуулийн үйл ажиллагааны зорилго:

Монгол Улсын Их Сургуулийн алсын хараа нь "дэлхийн түвшний их сургууль" болоход оршино.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгын хүрээнд 2024 онд МУИС нь чөлөөт мэдлэг буюу "либерал арт" уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж, улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орох зорилт тавин ажиллаж байна. Энэхүү алсын харааны хүрээнд МУИС нь шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу "либерал арт" уламжлалд суурилсан хөтөлбөртэй, байгалийн ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт, судалгааны ажлыг тогтвортой эрхэлж, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой академик буюу эрдмийн байгууллага болно.

Монгол Улсын Их Сургуулийн үйл ажиллагаанаас нийт 46,299,986.48 мянган төгрөгийн орлого олсон байна. Үүнд:

- Бакалаврийн сургалтын орлого
- Магистрийн сургалтын төлбөр
- Докторын сургалтын төлбөр

	ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01	ХЭЗГААРДАЛТАЙ САНАД ДҮГНЭЛТ
34,815,132.41	мян.төг
2,001,193.95	мян.төг
390,143.04	мян.төг

➤ Гадаад оюутны төлбөр	1,231,804.27 мян.төг
➤ МСҮТ-ийн сургалтын төлбөр	9,042.0 мян.төг
➤ Лицей сургуулийн сургалтын төлбөр	471,270.11 мян.төг
➤ Оюутны байрны орлого	907,189.57 мян.төг
➤ ЭШ-ний гэрээт ажил, төсөл	2,230,080.57 мян.төг
➤ Хадгаламжийн хүүгийн орлого	1,913,651.39 мян.төг
➤ ААТ нэгжийн орлого	934,237.38 мян.төг
➤ Түрээсийн орлого	129,336.54 мян.төг
➤ Хандив орлого	200,292.91 мян.төг
➤ Бусад хураамж, түр сургалт, диплом	1,066,612.94 мян.төг

Тайлант онд 2017 оны Засгийн газрын тогтоолоор тус сургуулийн бүрэлдэхүүнд байсан Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд сургуулийг Монгол Улсын Их сургуулиас тусгаарлан Худалдаа Үйлдвэрлэлийн Их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан ба шилжүүсэн хөрөнгийг Засгийн Газрын Капитал /Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт/ дансыг 3,590.4 сая төгрөгөөр бууруулан бичсэн байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монгол Улсын Их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 63 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Монгол Улсын Их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Монгол Улсын Их сургууль нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн Powersoft болон Excel програмуудыг ашиглан бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлан бодох үүрэг дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь



материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын Их сургууль нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,099.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 237.4 сая төгрөг, бусад төсөвт байгууллагаас 3,922.6 сая төгрөг, тусгай зориулалтын сангаас 1,225.8 сая төгрөгийн санхүүжилт авсан.

Өөрийн үйл ажиллагаанаас 43,165.4 сая төгрөгийн орлого олж, хандиваар 492.9 сая төгрөгийн орлого олсон байна.

Үндсэн үйл ажиллагааны зардалд 39,732.9 сая төгрөгийг зарцуулж 10,441.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Их сургууль нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна.

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн зорилтот түвшин, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт зэрэг мэдээллийг оруулсан. Шилэн дансанд нийт 145 мэдээ оруулах ёстойгоос 142 мэдээг оруулсан байна. Хугацаа хоцорч оруулсан 84 мэдээ, хугацаандаа оруулсан 58 мэдээ байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 63 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.


Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

1. Захирлын А/341 дүгээр тушаалаар үндсэн хөрөнгийн тооллого явуулах шийдвэртэй ч 42,222.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд тооллого хийсэн тухай илтгэх хуудасгүй, тооллогын дүнг нэгтгэсэн тайлан эцэслэн гараагүй байна.

Тус сургуулийн үндсэн хөрөнгийн 2017 оны жилийн эцсийн тооллогын дүнг эцэслэн нэгтгэлгүйгээр санхүүгийн тайлан гаргасан байна.



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг хийнэ”, 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч...”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх;

2. Төрийн өмчийг түрээслүүлэх гэрээ байгуулаагүйгээс 6.4 сая төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2.14-д “төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар батлуулан Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт дутуу төвлөрүүлсэн 6.4 сая төгрөгийн түрээсийн орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох;

3. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 17,783.3 сая төгрөг байна. Актлагдсан болон данснаас хассан хөрөнгөнд хамаарах 4,770.3 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны дүнг хорогдуулаагүй байна.

Энэ нь НББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 50 дугаар зүйлд “дахин үнэлсэн хөрөнгө нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, уг хөрөнгийг худалдсан эсвэл данснаас хассан үед дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч, уг хөрөнгийн хувьд дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлагдсан дүнг, хуримтлагдсан үр дүнгийн дансанд шилжүүлэн бүртгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Актлагдсан болон данснаас хассан хөрөнгөнд хамаарах дүнгээр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны дүнг хорогдуулан бүртгэх талаар зөвлөмж хүргүүлэх;

4. Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр 30,752.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 19,080.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-д “төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна”;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, шийдвэрлүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

зохицуулалтын газарт тавьж
01 ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам-ыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

2.9.2 Өглөг, авлагын талаар

Тайлант оны эцэст 5,710.7 сая төгрөгийн өглөг, 2,024.4 сая төгрөгийн авлагатай байна.

Өглөгийн 305.2 сая төгрөг, авлагын 578.3 сая төгрөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

2.9.3 Худалдан авах ажиллагааны талаар

Тайлант онд 5,996.7 сая төгрөгийн худалдан авалт хийхдээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нээлтийн тэмдэглэл хөтлөөгүй, тендерт оролцогчдод албан тоот мэдэгдэл хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3-д “тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл авах, тендер ирүүлэх хаяг”, 21.5.7-д “тендер нээх хугацаа”, 26.3-д “тендер нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, тендерийн хувилбарт саналтайгаар ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ, мөн тендерт тусгасан үнийн хөнгөлөлт, тендерийн баталгаа ирүүлсэн эсэх, оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн, эсвэл татгалзсан тухай мэдээллийг захиалагч зарлаж тэмдэглэл үйлдэнэ”; 26.4-д “Энэ хуулийн 26.2-д заасан этгээд захиалагч байгууллагын төлөөлөгч 26.3-д заасан тэмдэглэлд гарын үсэг зурна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэх;

2.9.4 Мөнгөн хөрөнгийн талаар

Гадаад оюутны сургалтын төлбөр, буфет, заалны түрээсийн төлбөр, хандивын орлого болон тендерийн материалын 2,457.1 сая төгрөгийн орлогыг бэлнээр хүлээн авч зарцуулсан ба кассын бүртгэлийн дэвтэр хөтлөгдөөгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 7.2-т “Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж, кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан, дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр, нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

2.9.5 Зардлын талаар

Тус сургууль байгуулагдсаны 75 жилийн ой болон бусад баяр ёслолын арга хэмжээнд 787.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын 3.6-д “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 147 дугаар тогтоолыг зөрчин баяр ёслол, ойн арга хэмжээнд зарцуулсан 787.0 сая төгрөгт албан шаардлага тогтоох;

2.9.6 Дотоод хяналтын талаар

Дотоод хяналтын 2 ажилтантай ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД


Монгол Улсын Их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар сургалтын төлбөрийн орлого болон тус сургуулийн бүрэлдэхүүнд багтдаг хүрээлэн, төвүүдийн үйл ажиллагааг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Монгол Улсын Их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 100,959.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 43,009.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 6.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн 1 акт тогтоож, 57,944.1 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.



2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Монгол Улсын Их сургуулийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 40,036.4 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 400.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Дээрх алдаа зөрчлийн нөлөөллийг эс тооцвол, Монгол Улсын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч байна.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 17,783.3 сая төгрөг байна. Актлагдсан болон данснаас хассан хөрөнгөнд хамаарах 4,770.3 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны дүнг хорогдуулаагүй байна.

Энэ нь НББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 50 дугаар зүйлд “дахин үнэлсэн хөрөнгө нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, уг хөрөнгийг худалдсан эсвэл данснаас хассан үед дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч, уг хөрөнгийн хувьд дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлагдсан дүнг, хуримтлагдсан үр дүнгийн дансанд шилжүүлэн бүртгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Актлагдсан болон данснаас хассан хөрөнгөнд хамаарах дүнгээр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны дүнг хорогдуулан бүртгэх.

- Зөвлөмжийг хэрэгжүүлэн 2018 оны 07-р сарын 01-ны дотор ҮАГ-т хариу ирүүлэх

Эрсдэлүүд

Стандарт, хууль журам зөрчигдөх, үр дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



3.2 Үндсэн хөрөнгийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр 30,752.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 19,080.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-д “төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчигдөх, үр дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмыг хэрэгжүүлэн ажиллах.

- Зөвлөмжийг хэрэгжүүлэн 2018 оны 07-р сарын 01-ны дотор ҮАГ-т хариу ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.3 Өглөг, авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант оны эцэст 5,710.7 сая төгрөгийн өглөг, 2,024.4 сая төгрөгийн авлагатай байна. 305.2 сая төгрөгийн өглөг, 578.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах.

- Зөвлөмжийг хэрэгжүүлэн 2018 оны 07-р сарын 01-ны дотор ҮАГ-т хариу ирүүлэх

Эрсдэлүүд

Хууль, тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.4 Худалдан авах ажиллагааны талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Тайлант онд 5,996.7 сая төгрөгийн худалдан авалт хийхдээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нээлтийн тэмдэглэл хөтлөөгүй, тендерт оролцогчдод албан тоот мэдэгдэл хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3-д “тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл авах, тендер ирүүлэх хаяг”, 21.5.7-д “тендер нээх хугацаа”, 26.3-д “тендер нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, тендерийн хувилбарт саналтайгаар ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ, мөн тендерт тусгасан үнийн хөнгөлөлт, тендерийн баталгаа ирүүлсэн эсэх, оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн, эсвэл татгалзсан тухай мэдээллийг захиалагч зарлаж тэмдэглэл үйлдэнэ”, 26.4-д “Энэ хуулийн 26.2-д заасан этгээд захиалагч байгууллагын төлөөлөгч 26.3-д заасан тэмдэглэлд гарын үсэг зурна” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах.

- Зөвлөмжийг хэрэгжүүлэн 2018 оны 07-р сарын 01-ны дотор ҮАГ-т хариу ирүүлэх

Эрсдэлүүд

Хууль, тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.5 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Гадаад оюутны сургалтын төлбөр, буфет, заалны түрээсийн төлбөр, хандивын орлого болон тендерийн материалын 2,457.1 сая төгрөгийн орлогыг бэлнээр хүлээн авч зарцуулсан ба кассын бүртгэлийн дэвтэр хөтлөгдөөгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 7.2-т "Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж, кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан, дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна" гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөн ажиллах.

- Зөвлөмжийг хэрэгжүүлэн 2018 оны 07-р сарын 01-ны дотор ҮАГ-т хариу ирүүлэх

Эрсдэлүүд

Хууль, журам зөрчигдөх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



3.6 Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Дотоод хяналтын 2 ажилтантай ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах.

- Зөвлөмжийг хэрэгжүүлэн 2018 оны 07-р сарын 01-ны дотор ҮАГ-т хариу ирүүлэх

Эрсдэлүүд

Стандарт, хууль журам зөрчигдөх, хяналт алдагдах эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	21,673,512,194.94	23,763,897,746.03
	Кассанд байгаа бэлэн мөнгө	6,721,731.00	11,798,278.93
	Жижиг мөнгөн сан	-	-
	Банкинд байгаа бэлэн мөнгө- Төгрөг	16,834,930,834.58	22,829,274,839.96
	Банкинд байгаа бэлэн мөнгө- Гадаад валют	4,831,859,629.36	922,824,627.14
	Богино хугацаат хадгаламж	-	-
	Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-
	АВЛАГА	2,243,252,646.91	2,024,398,802.54
	Төлбөртэй үйлчилгээний авлага	710,443,564.00	497,434,567.38
	Бусад авлага	1,532,809,082.91	1,526,964,235.16
	Дотоод тооцоо	-	-
	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	-	-
	Урьдчилгаа тооцоо	-	-
	Урьдчилж гарсан зардал	-	-
	БАРАА МАТЕРИАЛ	2,235,411,518.95	2,273,901,679.07
	Түүхий эд материал	2,333,752.27	2,156,034.92
	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
	Бэлэн бүтээгдэхүүн	-	-
	Хангамжийн материал	2,233,077,766.68	2,271,745,644.15
	Мал, амьтад	-	-
	Бусад	-	-
	НӨӨЦИЙН БАРАА	-	-
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,152,176,360.80	28,062,198,227.64
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	-	-
	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	50,570,054,319.09	55,995,875,960.79
	Биет хөрөнгө	-	-
	Барилга, байгууламж	56,760,508,185.72	71,423,950,933.91
	Хуримтлагдсан элэгдэл	(30,186,115,544.48)	(29,555,043,854.37)
	Авто - тээврийн хэрэгсэл	369,408,436.00	354,393,936.00
	Хуримтлагдсан элэгдэл	(340,367,035.11)	(318,348,590.65)
	Машин тоног төхөөрөмж	13,000,786,862.68	16,430,694,092.82
	Хуримтлагдсан элэгдэл	(8,150,988,812.75)	(8,307,599,301.92)
	Тавилга эд хогшил	5,333,301,630.29	6,140,663,360.77
	Хуримтлагдсан элэгдэл	(3,310,565,223.36)	(3,106,096,431.44)
	Батлан хамгаалах болон цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	-	-
	Хуримтлагдсан элэгдэл	-	-
	Түүх соёлын дурсгалт зүйлс	-	-
	Хуримтлагдсан элэгдэл	-	-
	Номын фонд	2,496,687,298.50	2,442,971,120.14



Хуримтлагдсан элэгдэл	-	-
Бусад үндсэн хөрөнгө	308,946,405.00	294,594,077.50
Хуримтлагдсан элэгдэл	(195,240,780.50)	(177,971,230.85)
Дуусаагүй барилга, байгууламж	14,352,897,674.19	225,908,127.00
Биет бус хөрөнгө	-	-
Программ хангамж	237,855,070.52	257,351,389.12
Хуримтлагдсан элэгдэл	(107,059,847.61)	(109,591,667.24)
Хувьцаагаарх хөрөнгө оруулалт	100,000,000.00	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	50,670,054,319.09	55,995,875,960.79
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	76,822,230,679.89	84,058,074,188.43
ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧ	-	-
